

ӨМӨЗО дахь хуурын үлгэрийн ая аялгууны судалгаа

*СЭЦЭНМӨНХ**

*Монгол Улс, Улаанбаатар,
“СИТИ” Их Сургууль*

*Дэлгэрхүүгийн НАРАНЦАЦРАЛ***

*Монгол Улс, Улаанбаатар,
Шинжлэх Ухаан, Технологийн Их сургууль,
Нийгэм хүмүүнлэгийн сургууль,
Түүх, соёл, аялал жуулчлалын тэнхим*

Received: December 01, 2025 | **Accepted:** December 13, 2025 | **Published:** December 30, 2025

Хураангуй: Хуурч хүн тухайн үндэстний түүхэн үлгэр домог, амьдрал тэмцэл буюу ямар нэгэн амьтан араатны үлгэрийг найруулан дөрвөн утаст хуур¹ хөгжмийн ая айзамд нийцүүлэн, дуулах хэв маяг ба ярих үгийн урлагийг хослуулан хуурын үлгэрийг хэлдэг. Хуурын үлгэрийн үндсэн гурван элемент нь хуурч, хуур, үлгэр гурав болно. Энэхүү гүүгүлэлд хуурын үлгэрийн гарал үүслийг судлаачид хэрхэн үзсэн талаар мөн хуурын үлгэрийн ая аялгууны ангиллыг бичсэн болно.

Түлхүүр үг: бэнсэн үлгэр, туульч, дөрвөн утаст хуур, цоо хурах ач, сул ая

A Study of the Fairytales in the Inner Mongolian Autonomous Region

SEQINMUNGHE

*“CITI” University
Ulaanbaatar, Mongolia*

NARANTSATSRAL, D

Department of History, Culture and Tourism

¹ Дөрвөн утаст хуур-Монгол улсад хуучир гэдэг, Өвөр монголд хуур гэдэг.

* © Сэцэнмөнх, 2025
Email: 1378189499@qq.com

** © Д.Наранцацрал, 2025
Email: narantsatsral5@gmail.com, <https://Orcid.org/0000-0002-6493-8685>

Abstract: *A khuurch is a performer who composes and narrates a folk fairy tales drawn from a people's historical legends, life struggles, or tales involving animals by harmonizing them with the melodies of a four-stringed fiddle. In performance, the khuurch combines a singing style with spoken verbal artistry to present khuur storytelling. The three fundamental elements of khuur storytelling are the performer (khuurch), the instrument (khuur), and the fairytale (story). This article examines scholarly views on the origins of khuur storytelling and outlines classifications of its melodic patterns.*

Keyword: *fairy tale (bensen), a epic teller, four-stringed fiddle, melody of tsoo khurakh, only melody*

Удиртгал

Хуурын үлгэр бол ХХ зуунаас олон улсын эрдэмтдийн анхаарлыг татаж, урлаг судлалын нэгэн чухал судлагдахуун болсоор иржээ. Хэдэн зууны хөгжлийн түүхэн явцад хуурын үлгэр нь хөгжлийн гурван үе шатыг дамжин өнгөрчээ. Хөгжлийн эхэн үе дэх хуурчид нь Зостын чуулганы Харчин гурван хошуу, Түмэдийн хоёр хошууны нутаг дэвсгэрээр тархан дэлгэрч, голдуу Хятадын түүхэн романы орчуулгын Бэнсэн үлгэрийг хуурдан хэлж, хэл хэллэг, ур чадвар, мэргэжлийн хувьд хөгжсөн. Хөгжлийн дунд үед монгол үлгэрийг хэлсэн. 1990-ээд онд Өвөр Монголын хөдөө орон нутгаар шинэ соёл урлаг нэвтрэн орж, хуурын үлгэрийн хөгжилд буурах нөхцөл байдал үүссэн хэдий ч ХХI зууны эхэн үеэс дахин хөгжих хандлагатай болжээ.

Цаг хугацааны хувьд авч үзвэл хуурын үлгэрт хавсран хөгжимддөг дөрвөн утаст хуур бол Мин гүрний үед тухайлбал XVI-XVII зууны үед бий болжээ.

Чин улсын үе дэх Өвөр Монголын Зостын чуулганы Харчин хошуу бол хятад оронтой хамгийн ойрхон нутагшиж байсан юм. Иймээс тэдгээр газар орны Монголчууд Хятадын соёл урлаг, түүхэн үлгэрийг хүлээн авсан нь он цагийн хувьд харьцангуй эрт билээ.

Харин агуулгын хувьд XVIII зууны эхэн үеэс Инжинаш, Гулранз зэрэг эрдэмтэд Хятадын түүхэн романыг монгол хэлэнд орчуулж эхэлснээс Өвөр Монголын зүүн орны Монголчуудын дунд Бэнсэн үлгэр өргөнөөр тархан дэлгэрч Монголчуудын гоо зүйн таашаалд их өөрчлөлт гарсан байлаа. Тэр үед цоорч нар баатарлаг тууль хайлахаас гадна Бэнсэн үлгэрийг дөрвөн утаст хуураар хөгжимдөн хуурдах болсноор ард түмэнд таашаагдав.

Хуурын үлгэрийн судлагдсан байдал

Эрдэмтэд хуурчийн намтар түүх, зохиол бүтээлийг цуглуулж эмхэтгэн, нийтэлж хэвлүүлэхийн зэрэгцээ шинжлэн судалж, судалгааны эргэлтэд оруулсан. БНХАУ-ын зарим судлаачид хуурын үлгэрийн талаар судалгаа хийсэн байдаг хэдий ч ӨМӨЗО-ны судлаачдын хийсэн олон судалгааг дурдаж болно.

Хуурын үлгэрийн судалгааны байдал бол хуурын үлгэрийн үүсэл хөгжил, хуурын үлгэрийн ая, хөгжим, хуурын үлгэрийн тухай зан үйл, хуурын үлгэрийн

зохиол ба аман зохиолын харьцаа, хуурын үлгэрийн онцлог, хуурын үлгэрийн нэрийдэл, соёлын үндэс, уран сайхны дүр, хуурчийн намтар, хэв маяг, урсгал бүлэг зэрэг сэдвийн хүрээнд судлагдаж байна.

Судалгааны аргын хувьд 1950-д онд ангилан жагсаах, задлах аргыг хэрэглэж байсан бол 1980-аад оноос утга зохиолын онолын текст судлалын арга, зан үйлийн онол, хүн судлалын онол, тоглоомын онол, харьцуулсан утга зохиолын онол гэх мэт олон онол арга зүйгээр судлах болсон байна. Гэвч хуурын үлгэрийн аяны бүтцийн талаас системтэй судалсан бүтээл харьцангуй бага байна. Өнөөг хүртэл хуурын үлгэрийг бүх талаас нь системтэйгээр судалсан бүтээл гараагүй байна.

1950-д оноос одоог хүртэл хуурын үлгэрийг цуглуулан эмхэтгэх ажлыг анхааралдаа авч, зарим хуурын үлгэр буюу хуурын үлгэр дэх хэвшмэл хэллэг, ая аялгуунуудыг цуглуулан эмхэтгэж хэвлүүлэн нийтлүүлж байлаа.

Хуурын үлгэр бол үг аянаас бүтсэн ардын аман урлаг юм. Иймээс үгийг тэмдэглээд аяыг тэмдэглэхгүй бол тэр нь бүрэн бүтэн үлгэр болж чадахгүй. Өнгөрсөн хугацаанд хуурын үлгэрийг бичиж тэмдэглэж хэвлүүлсэн бүтээл олон харагддаг боловч голдуу хуурын үлгэр дэх шүлгийг тэмдэглэж, үг аяыг хамтад нь тэмдэглэсэн маш цөөн байдаг. Гэвч 1980-аад оны эхэн үеэс хуурын үлгэрийн аяыг тусгайлан цуглуулан эмхэтгэж нийтлүүлэн хэвлүүлж эхэлжээ.

Хуурын үлгэрийн гарал үүсэл

Хуурч бол хуурын үлгэрийг үүсгэн бүтээгч юм. Хуурч нь хуурын үлгэрийг үүсгэн бүтээх тэрхүү агшинд үлгэр түүх хэлдэг өөрийн бие буюу “Хуурч” -ийг мөн үүсгэн бүтээсэн гэсэн үг. Иймээс хуурч ба хуурын үлгэр хоёр бол нэгэн газарт нэгэн цаг мөчид буй болсон гэж үзэж болно. Хуурч ба хуурын үлгэр нь нэг цагт нэгэн газар оронд бий болсон тул хуурын үлгэрийн үүслийн газар орон ба цаг үе нь хуурчийн үүслийн газар орон судлал, цаг үе гэж хэлж болно.

Хуурчийн үүсэл гарлын тухай судалгааг үндэслэвэл, хуурчийн үүсэл гарал ба түүний хөгжил нь мангасын үлгэр хэлдэг цоорч (туульч)-той салж болшгүй харьцаа холбоотой байжээ. Хуурч нь цоорчоос үүсэлтэй байснаар үл барам бас урт хугацаагаар цоорчтой өрсөлдөн тэмцэлдэж орон байр булаалдаж, эцэстээ цоорчийг ялж орон суудлыг нь эзлэн суув (Ган, 2019: 95). Зарим эх сурвалжид нэлээд эрт үеийн хуурч нарын олонх нь цоорч байжээ. Тэд цоор агтан мангасын үлгэр хэлж байснаа хуур агтан хуурын үлгэр хэлэх болов. Бас зарим нь цоор ба хуурыг хамт үүрэн явж, мангасын үлгэр хэлэхдээ цоороор хавсарган хөгжимдөж, хуурын үлгэр хэлэхдээ хуураар хавсарган хөгжимдөж байжээ. 150 жилийн өмнө, XIX зууны 30-аад оны үед Жарууд хошуунд нэртэй туульч олон байжээ. Түүний дотроос нэрт туульч Гэндэн хуур цоорын эрдэмд төгс гаршсан нэгэн бөгөөд мангасын үлгэр хэлэхдээ цоороор хавсарган хөгжимдөж, хуурын үлгэр хэлэхдээ хуураар хавсарган хөгжимддөг (Нямаа, 1990).

Хуурч ба хуурын үлгэр маш их тархан дэлгэрсэн Чин улсын үе дэх Өвөр Монголын зүүн орон Зост, Жирэм, Зуу уд зэрэг гурван чуулганы дотор Зостын чуулган нь өмнө хэсэгт байрлаж, Хятадтай зах хязгаар нийлж байгаа тул хятад соёл цаг хугацааны хувьд эрт нэвтрэн орсон орон нутаг юм. Зостын чуулганд Харчин баруун гарын хошуу, Харчин дундад хошуу, Харчин зүүн гарын хошуу, Түмэд зүүн гарын хошуу, Түмэд баруун гарын хошуу зэрэг таван хошуу багтана. Харчин дундад хошуу, Харчин баруун хошуу нь Хятадтай ойролцоо байрлаж

байсан.

Хятадын байгалийн гамшиг, цэрэг дайны хөлөөс зайлж умар зүг рүү нүүдэллэсэн Хятадууд Цагаан хэрмийг давж, Ши фэн Кеү-гээр өнгөрөнгүүт Зостын чуулганы нутагт орж ирдэг (Хувьсгалт, 2013: 15-16). Ши фэн Кеү, Хэбэй бол Шандун, Хэбэй мужийн хятад тариачид Харчин нутагт нутаглах нь ихэссэнээр хятад үндэстний үг хэл, үсэг бичиг хийгээд түүхэн үлгэр зэрэг нь Харчин монголчуудад маш их нөлөөлөх болжээ. Үүний улмаас Харчин нутагт Инжинаш шиг монгол, хятад бичигт нэвтэрсэн эрдэмтэд цойлон гарч байв. Тухайн үед тэдгээр монгол, хятад бичигт нэвтэрсэн эрдэмтэд Хятадын соёл урлагийг Монголчуудад түгээхийн тулд Хятадын түүхэн романыг монголчилж хэвлэж байлаа. Жишээлбэл: “Чен Де дэх найман орны хамаарагчийн хадгалж байгаа” “Шан улсын үлгэр” (Сахиулсан өргөмжлөн битүүмжилсэн тууж)-ийн хамгийн сүүлийн хуудсанд Харчин баруун гарын хошууны Мар хорооны Буу Шиян хөх хулгана жилийн ла сард Сахиулсан өргөмжлөн битүүмжилсэн туужийг Монгол Майдарын дор өргөв гэж бичжээ” (Монгол үндэстний утга зохиолын материалын эмхэтгэл, VII дэвтэр, дотоод материалын оршил 1980, 6). Тэдгээр эрдэмтдийн орчуулсан Бэнсэн үлгэр нь хуурчдын хуурдан ярих үлгэрийн чухалагуулга нь болж байжээ. Нөгөө талаар хуурч ба хуурын үлгэрийн үүссэн тухайн газар оронд Хятад үндэстний түүхэн роман байхаас гадна Монгол үндэстний баатарлаг туульч байх хэрэгтэй.

Бид Харчин нутагт туульч буюу баатарлаг тууль тархан уламжлагдаж байсан жишээг дурдъя. XIX зууны 20-30-аад оны Харчинд туульч олон байсан. Хуурч Шуушингаа, Лахару нар бол энэ үед төрсөн хүн. Цоорч Насангөмөрт цоор хөгжимдөх ба хуурын үлгэр зааж байсан (Нямаа, 1990). Ли Фү Чин “Бэнсэн үлгэр ба аман зохиолын харилцаа холбоо” гэдэг өгүүлэлд Өвөр Монголын Шилийн гол, Монгол улсын нутгаар тууль хайлан үлгэр ярьж явсан нэрт хуурч Самбуудаш (1928) бол харчин хүн юм гэж тэмдэглэжээ (Чин, 1990).

Харчин баруун гарын хошууны засаг ван Ванданнамжилын үед вангийн ордонд бичээч, захирагч зэрэг албан тушаал хашиж байсан Баянбилиг (Хятад нэр нь ван Гүе Жүн, 1853-1921)-ийн бичсэн “Монголын тухай тэмдэглэл” гэдэг номд харчин Монголчуудын түүх, улс төр засаг, сурган хүмүүжил, цэрэг дайн, зан үйл зэргийг тэмдэглэхийн хамт бас ардын үлгэр домгуудыг ч тэмдэглэжээ. Тэдгээр үлгэр домгийн дотор “Мангасын тэмдэглэл” гэдэг үлгэр домог бий. Эдгээр жишээ баримт нь, харчин Монголчуудын дунд нэлээд эрт үеэс туульч ба баатарлаг тууль тархан уламжлагдаж байжээ гэдгийг гэрчилж байна.

Хуурын үлгэрийн ая аялгууны ангилал

Хуурын үлгэрийн “ая” гэдэг үгний ойлголт бол бидний өдөр тутам хэрэглэдэг ая аялгуу гэдэг үгтэй адилгүй, хөгжимт аман аялгуу юм. Жишээлбэл: “цоо хурах ая”¹.

¹ Цоо хурах ая – хуралдай хурах үед хэрэглэгддэг.



Зураг 1. Хуурын үлгэрийн үлгэр эхлэх сул ая

Бүтцийн хувьд эхний 17 такт аялгууг хуураар хөгжимдсөн. 18, 19, 20 тактад хуурч хөгжимгүйгээр хүүрнэн дуулж, 21 тактад хуурын үлгэрийн холбоос ая орж ирнэ. Ийм хэлбэрээр ээлжлэн хөгжимт аман аялгуугаар хэлж, үлгэрийн агуулгаа өрнүүлдэг. Иймээс энэ

ая аялгууг тус тусад нь бичих буюу хүүрнэн дуулах хэсгийг тусад нь бичдэггүй, аялгуу үг нийлж байж нэг аяыг бүрдүүлнэ.

Хуурын үлгэрийн “ая”-ыг тоглох онцлогоос нь хамаарч “ая” болон “сул ая” гэсэн хоёр төрөлд хувааж болно.

1. Ая (дуулах ая)

Хуурын үлгэрийн “ая” гэдэг нь хөгжмийн тодорхой илэрхийлэлтэй, аялан дуулах шинж чанартай байдаг. Хэмнэл, аялгууны явц нь тодорхой дүрэм журамтай, айзам нь жигд, бүтэц нь тэгш байдаг. Хуурын үлгэрийн аяыг хүүрнэх ая ба уянгын ая гэж хоёр төрөлд хуваана.

Хүүрнэх ая гэдэг нь хуурч хүүрнэн дуулах хэлбэрээр үлгэрийн агуулгаа өрнүүлэх хэлбэр юм. Аялгууны онцлогийн хувьд тогтмол цохилготой, жигд хэмнэлтэй, дунд зэргийн цараатай, жигд бүтэцтэй. Аялгуут шүлгийн илтгэх хэлбэр нь тоочилт, дүрслэл, зураглал зэрэг болно. Хүүрнэх аянд хамрагдах үлгэрийн аяыг жагсааваас:

- ✓ Үлгэрийн эхлэл ая- үлгэрийн удиртгал ая, түүх товчлох ая, үлгэрийн явцыг тушаах ая гэх мэт хуурч бүр өөр өөрийн хэв маягаар аялгуулан хэлнэ. (Зураг 2)



- ✓ Цоо хурах ая (хуралхуралдах ая)-хаад түшмэдийн цоод² залран саатах, сайд түшмэл айлтгал дэвшүүлэх, хаанаас ард түмний байдлыг асуух, цэргийн байдлыг мэдээлэх, төрийн хэргийг хэлэлцэх зэрэг утга агуулгатай.

- ✓ Цэрэг мордох ая-их цэрэг жагсах, мордох, замнах, буудаллах, дайсны цэрэг ирэх, буудаллах, цэргийн хүнс зөөх зэрэг утга агуулгатай.

- ✓ Тулааны ая-Жанжин хуяг дуулгаа өмсөх, тушаал өгөх, цэрэг

тулалдахад бэлтгэж жагсах, хоёр талын жанжид тулалдах зэрэг утга агуулгатай.

- ✓ Зам хөөх ая-Хувилгаан сахиус уулнаас буух, шуламс уулнаас буух, гүнж

² Цоо - хуралдай

замд гарах, дайсан замд гарах, шөнөөр замд гарах зэрэг утга агуулгатай.

Магтаал ая -уул усны магтаал, хөгжин бадарсан цаг үеийг магтах, хагагтай нарыг магтах, баатруудыг дуулах, морьдыг магтах, үнэнч шударга сайдыг магтах гэх мэт ая орно.

Хошин ая -муу хүмүүсийг дүрслэх, хуйвалдаж хүн хорлох, харгис эзнийг хараах зэрэг ая орно

Харилцан ярилцах ая-харилцан ярилцах ая, амар асуух ая, байцаан асуух ая, хараах ая, хэрэг шүүх ая зэрэг орно.

Тоочин хэлэх ая-өнгөрсөн үйл явдлаа тоочих, цэргийн зарлиг унших, хааны зарлигийг буулгах, захидал унших зэрэг ая орно.

Ёс суртахууны ая-өвөг дээдсээ тахих, тэнгэр газар тахих, зочдыг угтах, найр хурим хийх зэрэг ая орно.

Ялалтын ая-дайснаа дарж нутагтаа буцах, гавьяатан сайдыг шагнах, зэрэг цол өргөмжлөх, ялалтаа тэмдэглэх, баяр ёслол хийх

Төгсгөл ая -жаргаах ая орно.

Уянгын ая нь үлгэр дэх уран сайхны дүрийн эмгэнэлтэй категорийг илтгэх дотоод сэтгэлийн хөдөлгөөнийг гаргасан төрөл садан, нутаг усаа мөрөөдөн санагалзах ая болно.

Уйтгар гунигийн ая-үлгэр дэх уран сайхны дүр гашуун зовлонд учрах, уйтгар гуниг, харамсал гэх мэт дотоод сэтгэлийн хөдөлгөөнийг илтгэх ая юм.

Санан мөрөөдөх ая -эх орноо, аав ээжээ, эхнэр хүүхдээ, найз нөхдөө, хаан эзнээ, янаг хонгороо санагалзах ая.

Сэтгэлээ илтгэх ая -гомдол тоочих, салж яваад удсан хойно санасан сэтгэлээ илтгэх ая.

2. Сул ая (ярих ая)

“Сул ая” бол зөвхөн хуурын үлгэрийн хөгжимд байдаг. Хуурын үлгэрийн аялгуу дахь “ая” (дуулах ая), “сул ая” (ярих ая) хоёрын ялгаа: “ая” нь аялгуулан дуулна, илтгэх утга нь тодорхой чиглэлтэй байдаг, тухайлбал “Цоо хурах ая”, “Дайны ая” зэрэг., “сул ая” нь ярих дуулах хоёрын дунд үглэл маягаар дуулдаг, аялгуу нь жигд бус, аялгууны кульминаци тогтворгүй, хөгжмийн өгүүлбэр адилгүй, чөлөөтэй, дуулах явцад ихэнхдээ хөгжимгүй, зөвхөн ярих өгүүлбэрийн хооронд буюу догол мөр хооронд холбоос ая болдог.

Нэгдүгээрт ярьж дуулахад хөгжим зогсож, хуур хөгжимдөх үедээ дуулахгүй. Үүнээс харвал тус нэг бадаг шүлэг нь таван мөр шүлэгтэй. Үүний дунд хоёр удаа холбоос ая оржээ.

За, үлгэрийн учир уламжлаад хэлбэл-{холбоос ая1}-Улсын нэрийг заавал дан улсаар нэртээд, дан улсын эзлээд суусан нийслэл хот нь цан аан газар-{холбоос ая2}-Дан улсыг эзлээд суусан хүний овог нь Ли овогтой, дол оодугаар үеийн хааны цол нь Сүзун Хуанди Ли енхэмээжээ. За өгүүлэх ану үлгэрийн дараа {холбоос ая} төмөр хаа тасарвал тэнд нь давтаж, түүхэн үлгэр хаа хүрээд зогсвол түүнээс залгамжилна,

Хоёрдугаарт, сул ая нь дуулах болоод хөгжмийн аялгууны хэлбэр онцлог нь адилгүй, дуулах хэсгийн бүтэц нь чөлөөтэй, айзам нь тогтмол биш, холбоос ая нь харьцангуй тогтсон дүрэмтэй, үйлдэл нь хоёр хэсэг адил бус хэлбэртэй, аялгууны өгүүлбэрийг холбон зохицуулна. Сул аяыг дээрх хэлбэрээр ээлжлэн аялгуулан уншиж, ая дуусах үед хөгжимдөн дуулж аяыг төгсгөнө. Сул аяны шүлэг ба хөгжмийн нийлэмжийн онцлог бол өвөрмөц. Холбоос ая нь хоёр такттай байх эсвэл нэг өгүүлбэр аялгуу ч байж болно. Мөн үгийн дунд хөгжмийн

татлага орж ирдэг. Тухайлбал: Удиртгал ая→{үглэх + холбоос ая + үглэх} → төгсгөлд нь (дуулах + холбоос ая).

- Холбоос ая нь бичгийн цэг таслалтай адил хоёр фразыг холбодог тул сонсогчид үлгэрийн агуулгыг ойлгож чадна.
- Сул ая нь тоглож байгаа хуурчид тоочин илтгэх үгийг аялгууны бүтцийн дагуу оновчтой зохион байгуулахад тус болно.
- Холбоос ая нь хуурчид дараагийн өгүүлбэрийг хэлэхэд тодорхой хэмжээний сэтгэн бодох цаг гаргаж, дууны үгийг илүү сайн илэрхийлэх боломжийг олгоно.

Дүгнэлт

Хуурын үлгэр үүсээд бараг хоёр зуугаруй жил болжээ. Энэ хугацаанд олон хуурчид маш олон хуурын үлгэрийг ярьсан. Гэвч одоо болтол цуглуулж эмхэтгэн, хэвлэж нийтлэгдсэн хуурын үлгэр цөөн байна. Олонх хуурын үлгэр нь ардын аман зохиолын онцлог шинжээсээ болж уламжлагдаж ирсэн нь цөөн.

Хуурч ба хуурын үлгэрийн үүслийн газар орон нь хоёр нөхцөлөөс болж бүрэлдсэн байна. Нэгд, газар зүйн үүднээс үзвэл, Хятад үндэстний соёл урлаг Монгол оронд нэвтрэн ороход хялбар байсан. Монгол улс Хятад улстай өмнөд хэсгээрээ хиллэдэг. Хоёрт, тухайн газар оронд Монгол үндэстний туульч ба баатарлаг тууль тархан дэлгэрч байсан.

Хуурын үлгэр нь дөрвөн утаст хуураар хөгжимдөн үлгэр хэлэх юм. Хуур бол монгол үндэстний уламжлалт хөгжмийн зэмсгийн нэг болно. Дөрвөн утаст хуурыг дээд ба доод хөгийн дөрвөн утаст хуур гэж хоёр ангилна. Дээд хөгийн дөрвөн утаст хуурын утсыг төмөр утсаар хийдэг учраас дууны өнгө нь хангинам тул хуурчийн аргил хоолойтой нийцэхгүй учир хуурч нар үлгэр хэлэхэд доод хөгийн дөрвөн утаст хуураар хавсарган тоглодог байна. Доод хөгийн дөрвөн утаст хуурын утсыг мяндсаар бүтсэн ёнхор утсаар хийдэг. Дууны өнгө нь хүнгэнэм байснаар хуурчийн хоолойны өнгөтэй тун ойролцоо тул хуурч нар үлгэр хэлэхдээ доод хөгийн дөрвөн утаст хуурыг хэрэглэдэг.

Бид дээрх судалгаанд үндэслэн хуурчийн үлгэр хэлэх загварыг гаргалаа.

шүлэглэн дуулах тиг + хүүрнэн дуулах

Хөгжимдөн дуулах, ярих хоёр ээлжлэн илэрч, харилцан зохицолдон өгүүлж үлгэрийн агуулгаа тогтоож чадсанаар хуурын үлгэр нь үе улиран хөгжиж иржээ.

Ном зүй

- Ган, Б. Ж.** (2019). *Хуурчийн судлал*. Леонин: Леонины Үндэстний хэвлэлийн хороо. [Gan, B, J. khuurchiin sudlal, Leoninii undestnii khevleliin khoroo. 2019.]
- “*Монгол үндэстний утга зохиолын материалын эмхэтгэл*” (1980). VII дэвтэр. Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн утга зохиол судлах газар. [Compilation of Literary Materials of the Mongolian Nation”, Book VII. Department of Literary Studies of the Inner Mongolian Institute of Social Sciences. 1980.]
- Нямаа.** (1990). Зүүн Монголын эртний туульч хийгээд туулийн тархалтын тухай тэмдэглэл. Алтан түлхүүр. [Nyamaa. “Notes on the Distribution of Ancient Epic

Writers and Epics in Eastern Mongolia”. Golden Key. 1990.]

Хувьсгалт. (2013). Хуурын үлгэрийн үүсэл бүрэлдлийн судалгаа. Төвийн Үндэстний Их Сургуульд докторын зэрэг хамгаалсан диссертаци, Төвийн Үндэстний Их Сургууль. [Khuvsgalt. “A Study on the Origin and Formation of the Fairy Tale”. Doctoral Dissertation at the Central University of Nationalities, Central University of Nationalities. 2013.]

Цогт. (2002). Хуурын үлгэрийн судлал. Үндэстний хэвлэлийн хороо. [Tsogt. The Study of Fairy Tales. National Publishing Committee. 2002.]

Чин, Ли Фү. (1990). Бэнсэн үлгэр ба аман зохиолын харилцаа холбоо//*Монгол материал ба мэдээлэл сэтгүүл*. [Qing, Li Fu. “The Relationship between Fairy Tales and Oral Literature”. Mongolian Journal of Materials and Information, 1990.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution NonCommercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See:

<http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

